



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/480

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл 32.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.5, Булган аймгийн Онцгой комиссын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр хурлын тэмдэглэлийн 2.7, 2.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр "Хяналт шалгалтын удирдамж"-ийн дагуу Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар байгуулагдсан "Хамтарсан ажлын хэсэг"-ээс Булган сумын үерийн ус зайлуулах инженерийн барилга байгууламжид хийсэн хяналт, шалгалтын мөрөөр зөрчлийг арилгах, иргэдийн амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах үүргийн дагуу үерийн далангийн системийг цэвэрлэж, засварлах ажилд 50,000,000 (тавин сая) төгрөгөөр гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн Авто замын хяналтын Улсын байцаагч (С.Сүхбаатар), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д тус тус даалгасугай.

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010682

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн авто замын сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр тухай бүр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР